45

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2024 оны 09 сарын 03 өдөр Дугаар А/145 Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1 дэх заалт, 24.6 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан "Буцалтгүй тусламжийн хэлэлцээр"-ийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ази, Номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн Япон сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл"-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний Б11 багцын дугаартай хэрэгжүүлэгч байгууллагад тавилга, тоног төхөөрөмж барааны худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Н.Отгонбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн удирдлагын газрын дарга
Гишүүд:	Б.Мөнх-Эрдэнэ	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
	Э.Хишигбуян	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны төсөл хөтөлбөр, судалгаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
	Ц.Дарханбат	Тактижент ТББ-ын тэргүүн
Нарийн бичгийн дарга:	Д.Цэвээн-Үр	"Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл"-ийн худалдан авалт, гэрээний удирдлагын мэргэжилтэн

2.Энэ тушаалын 1 дүгээр хэсэгт заасан ажлын гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо (Н.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

3.Худалдан авах ажиллагаатай холбоотой түр баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэж архивд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Цэвээн-Үр)-д үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Ц.ТӨРХҮҮ